



ОЛОН УЛСАД МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН МАНДАХ ИХ СУРГУУЛЬ

NEWSLETTER

Магистрын хөтөлбөрийн төгсөлтийн ёслолын үйл ажиллагаа боллоо

Мандах Их Сургуулийн магистрын хөтөлбөрийн 24 дэх удаагийн төгсөлтийн үйл ажиллагаа 2022 оны 01 сарын 08-ны өдөр боллоо. Үйл ажиллагаанд Мандах Их Сургуулийн удирдлага, Эрдмийн зөвлөлийн гишүүд оролцож, төгсөгчдөд амжилт хүсье диплом энгэрийн тэмдгийг гардуулж өглөө. Энэ удаагийн төгсөлтөөр Нягтлан бодох бүртгэл, Санхүү, Банк, Бизнесийн удирдлага хөтөлбөрөөр нийт 32 магистрант төгслөө. Төгсөлтийн ёслолын үйл ажиллагааны үеэр 3.7-оос дээш голч дүнтэй суралцсан 11 төгсөгч, тус сургуулийн докторын хөтөлбөрт шалгалтгүй элсэн, эхний хичээлийн жилд сургалтын төлбөрийн 10% ийн хөнгөлөлттэй суралцах эрхийн бичиг, гарын бэлэгээр шагнуулаа.

Нийт төгсөгчиддөө цаашдын ажил хөдөлмөртөө өндөр амжилт гаргаж, сургуулийнхаа нэр хүндийг өндөрт өргөн, мэргэжлийн ёсоор зүйгээ чанд сахин ажиллахыг хүсье.




Үйл явдлууд

Peregrine Global Services байгууллагын хөндлөнгийн үнэлгээний шалгалтыг амжилттай өглөө

ACBSP-нь 60 орны 1260 гаруй гишүүнтэй дэлхийн хэмжээнд бизнесийн сургууль, хөтөлбөрүүдийг магадлан итгэмжлэдэг АНУ-ын боловсролын яамнаас хүлээн зөвшөөрөгдсөн анхны магадлан итгэмжлэлийн байгууллага юм. ACBSP байгууллагаар Мандах их сургууль 2012 онд байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийлгэсэн монголын анхны сургуулиудын нэг бөгөөд одоогоор монголын 13 их дээд сургууль магадлан итгэмжлэл хийлгээд байна. Бид жил бүр ACBSP-ийн Platinum Sponsor байгууллага болох Peregrine Global Services байгууллагын бизнесийн хөтөлбөртэй их, дээд сургуулиудад бизнесийн сургалт, боловсролын мэдлэгийн түвшинг тогтоох шалгалтыг өгч ахиц дэвшлээ үнэлүүлдэг. Төгсөх курсийн оюутнуудаас авдаг Outbound буюу гарцын шалгалт нь тухайн сургуулийн сургалтын чанарыг тодорхойлохоос гадна хөтөлбөрийн шинэчлэл, сайжруулалт ямар түвшинд хийгдэж байгааг харуулдаг гол шалгуурын нэг юм.

2021-2022 оны хичээлийн жилийн манай сургуулийн төгсөх ангийн оюутнуудын өгсөн Outbound –ын дүнг ACBSP-ийн 8-р бүсийн 15 сургуультай харьцуулж үзвэл өсөлтийн хувь өндөр байгааг тус байгууллагын тайлангаас харж болохоор байна. Нийт шалгалтанд орсон оюутнуудын 54%-нь өндөр оноо авч Peregrine Global Services байгууллагаас гэрчилгээ авах болзлыг хангаад байна.



Гадаад хэлний тэнхим “монгол хэл, соёл” өдөрлөгийг зохион байгууллаа

Мандах их сургуулийн II дамжааны оюутнуудын дунд “Монгол хэл, соёл” өдөрлөгийг 2022.04.07-04.08-ны өдрүүдэд монгол хэл бичиг, өв соёл, ёс заншлаа дээдлэх, МХНЗ хичээлээр сурч мэдсэн мэдлэг чадвараа сорих, харилцан бие биенээсээ суралцах зорилгоор дараах 5 тэмцээний хүрээнд 3 дахь удаагаа зохион байгууллаа. Өдөрлөгт нийт 235 оюутан хамрагдсан ба Дархан салбар сургууль, Мэдээлэл технологийн сургуулиас оюутнууд оролцов.

Оюутнууддаа цаашдын хичээл сурлагад нь өндөр амжилт хүсье!



Үйл явдлууд

"Өрхийн Санхүү" сэдэвт үнэгүй сургалтыг санхүүгийн мэдлэгээ нэмэгдүүлэх зорилготой хүн бүхэнд зориулан цахим хэлбэрээр зохион байгуулахаар боллоо

Мандах Их Сургуулийн 30 жилийн ойд зориулан ЭЗБТ-ээс "Өрхийн Санхүү" сэдэвт үнэгүй сургалтыг санхүүгийн мэдлэгээ нэмэгдүүлэх зорилготой хүн бүхэнд зориулан цахим хэлбэрээр зохион байгуулахаар боллоо. Энэхүү сургалтанд хамрагдсанаар хувь хүмүүс эдийн засгийн зүй тогтол, санхүүгийн мэдлэгээ сайжруулснаар өрхийн санхүүгээ сайжруулах арга замууд, боломжуудыг мэдэх, амьдралдаа ашиглах боломжтой болно. Сургалт дараах сэдвийн хүрээнд зохион байгуулагдана.

Зах зээлийн эдийн засаг, түүний мөн чанар. Багш Л.Дансранбавуу

Монгол Улсын хөрөнгийн зах зээл, боломжууд. Багш Г.Лхамдулам

Гадаад зах зээлд ашиг орлого боломжууд. Багш А.Дөлгөөн

FREE WEBINAR
ӨРХИЙН САНХҮҮ
СУРГАЛТ
financial training

30 НИЙЛ
СӨЛӨГӨЙ ХӨРӨНГИЙН
ГАНДАХ ИХ СУРГУУЛЬ

МАНДАХ ИХ СУРГУУЛЬ
1992
ИХ СУРГУУЛЬ

МАНДАХ ИХ СУРГУУЛЬ, ЭЗБТ
БАГШ, ДОКТОРАНТ
Г.ЛХАМДУЛАМ

МАНДАХ ИХ СУРГУУЛЬ, ЭЗБТ
БАГШ, ДОКТОРАНТ
Л.ДАНСРАНБАВУУ

МАНДАХ ИХ СУРГУУЛЬ, ЭЗБТ
БАГШ, МАГИСТР
А.ДӨЛГӨӨН

10 MAY 2022 **11:00 AM** 12:30 AM


9920-4112
9990-4560
DULGUUN.A@MANDAKH.EDU.MN
LKHAMDULAM@MANDAKH.EDU.MN

УУЛЗАЛТЫН ХОЛБООС

ХУВЬ ХҮНИЙ САНХҮҮГИЙН МЭДЛЭГЭЭ
ДЭЭШЛҮҮЛЭХИЙГ ХҮСЭЖ БҮЙ ХҮН БҮРТ ЗОРИУЛАВ.

Мандах их сургуулийн оюутнууд Ази, Номхон далайн орнуудын UMAP хөтөлбөрийн Олон улсын виртуал арга хэмжээнд амжилттай оролцлоо

Мандах их сургуулийн оюутнууд Ази, Номхон далайн орнуудын UMAP хөтөлбөрийн хүрээнд Индонези улсын Султан Агунг Исламын Их сургуулиас зохион байгуулсан Олон улсын виртуал арга хэмжээнд амжилттай оролцлоо. Арга хэмжээ 2022 оны 3-р сарын 21-нээс 3-р сарын 25-ныг хүртэл 5 хоног үргэлжилсэн бөгөөд Бангладеш, Малайз, Филиппин, Индонези, Монгол, Тайвань, Вьетнам зэрэг Азийн 7 орны их дээд сургуулийн 200 гаруй оюутнууд оролцсоноос Мандах их сургуулиас Нягтлан бодох бүртгэл-Татварын ангийн 3-р дамжааны оюутан П. Сансармаа, Асель Тилейбек, Нягтлан бодох бүртгэл-Мэдээллийн системийн ангийн 1-р дамжааны оюутан Н.Тэргэл нар оролцож, багт хуваагдан ажиллалаа. Багийн ажиллагааны нэгээхэн томоохон хэсэг нь “Соёлын солилцоо” буюу өөрийн улс орны соёл ахуй, зан заншлыг харуулсан видео контент бэлтгэж, бусад орны оролцогч нартаа танилцуулах үйл ажиллагаа байсан бөгөөд манай оролцогч нар Монголын соёл урлаг, ёс заншил, аж амьдралын талаар видео контент бэлтгэн, танилцуулсан нь бусад орны оюутнуудын сонирхлыг татаж, Монгол орныг үзэх хүслийг төрүүлж чадсан. Оролцогч оюутнууд “Нийгмийн сайн сайхан байдлын олон үндэстний хэтийн төлөв”, “Ковид-19 өвчин бидний сайн сайхан байдалд хэрхэн нөлөөлж байна вэ?”, “Ковид -19 өвчинтэй дасан зохицох чадварыг бий болгох” зэрэг сэдвээр лекц сонсож, өөрсдийн санал бодлоо хуваалцан, туршлага хуримтлуулсан үр өгөөжтэй үйл ажиллагаа боллоо.



Инженерийн хөтөлбөрийн анхны диплом хамгаалалт амжилттай зохион байгуулагдлаа

Мандах Их Сургуулийн 2021-2022 оны хичээлийн жилийн Механик инженер хөтөлбөрийн Инженер эдийн засгийн ангийн оюутнуудын анхны диплом хамгаалалт 2022.05.06-ны өдөр амжилттай явагдлаа.

Оюутнууд маань дипломын төслөө инженерийн чиглэлээр хийсэн тооцоон дээр үндэслэж SolidWorks программд инженерийн зургуудаа зурж, эдийн засгийн тооцоог хамтад нь хийсэн онцлогтойгоор гүйцэтгэлээ.

Хамгаалалтад нийт 16 оюутан оролцож, 4 жилийн хугацаанд танхим болон цахим хэлбэрээр суралцан өөрийн мэргэжил, салбарын хүрээнд хийсэн судалгааны ажлаа инженерийн чиглэлээр диплом хамгаалах комиссын гишүүдээр хэлэлцүүлж, амжилттай хамгааллаа.



Бизнесийн чиглэлийн дипломын хамгаалалт амжилттай зохион байгуулагдлаа

Мандах Их Сургуулийн 2021-2022 оны хичээлийн жилийн нягтлан бодох бүртгэл, санхүү, банкны хөтөлбөрийн оюутнуудын диплом хамгаалалт 2022.05.04-ны өдөр зохион байгуулагдлаа. Хамгаалалтанд нийт 29 оюутан оролцож, 4 жилийн хугацаанд танхим болон цахим хэлбэрээр суралцан өөрийн мэргэжил, салбарын хүрээнд хийсэн судалгааны ажлаа хамгаалах зөвлөлийн комиссын гишүүдээр хэлэлцүүлж, амжилттай хамгааллаа.



Мандах их сургуулийн гадаад хэлний тэнхмээс уламжлал болгон зохион байгуулдаг “гадаад хэлний сургалтын өнөөгийн чиг хандлага вебинар - 2022” амжилттай болж өндөрлөлөө

Мандах их сургуулийн Гадаад хэлний тэнхмээс “Гадаад хэлний сургалтын өнөөгийн чиг хандлага-2022” сэдэвт онол, арга зүйн семинарыг 2022 оны 4 сарын 09-ны өдөр улсын хэмжээнд 5 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. Энэ жилийн семинар нь Zoom платформ ашиглан Webinar хэлбэрээр явагдсан ба нийт 115 эрдэмтэн судлаач, профессор, багш оролцож гадаад хэлний хичээлийн сургалтын хөтөлбөрийн шинэчлэл чиг хандлага, сургалтын дэвшилтэт технологийн практикт суурилсан судалгааны үр дүнгээ хэлэлцэн, арга туршлагаа хуваалцлаа. Вебинарын зочин илтгэгчээр МУИС-ийн доктор (Ph.D), профессор Н.Нансалмаа “Тархи судлалд суурилсан орчин үеийн шинжлэх ухааны ололтыг гадаад хэлний сургалтад ашиглах нь” ХИС-ийн доктор (Ph.D), дэд профессор Н. Оюунцэцэг, “Сургалтын хөтөлбөрийн өрсөлдөх чадамжийг нэмэгдүүлэхэд суралцахуйн үр дүнг оновчтой тодорхойлох асуудалд” (Орчуулагч хөтөлбөрийн жишээн дээр), МУИС-ийн доктор (Ph.D), ахлах багш С.Чимэдцогзол “Нийгэм хүмүүнлэгийн салбарын диссертацийн хураангуйн онцлог, түүнийг хэрхэн бичих нь”, Мандах их сургуулийн ахлах багш, докторант Ж.Төгсөө “Англи хэл суралцагчдын үгийн нөөцийг тодорхойлох хэрэгцээ, арга зам” ахлах багш Н.Ариунаа, Ш.Нандинцэцэг нар “Цахим сургалтанд мэдээллийн технологи ашиглах нь” /Англи хэлний хичээлийн жишээн дээр/ сэдвээр тус тус илтгэл хэлэлцүүлж гадаад хэлний өнөөгийн чиг хандлагыг сургалтын хөтөлбөр, нэгж хичээл, семинарын хичээлд хэрхэн үр дүнтэй нэвтрүүлэх талаар судалгаанд үндэслэсэн сонирхолтой мэдлэг, мэдээлэл өглөө. Онлайн вебинарт оролцогчдын 67.6% нь ЕБС-иас, 39.5% нь их дээд сургуулиас, бусад байгууллагаас 1.9%-тай хамрагдсан ба тэдгээр оролцогчдын 81.9% нь УБ хотоос, 18.1% нь хөдөө орон нутгаас оролцсон нь вебинар онлайнээр зохион байгуулагдаж байгаагийн нэг давуу тал болсон гэж дүгнэж болохоор байна. Вебинарт оролцогчдоос семинарын талаарх сэтгэгдэл болон, цаашид анхаарах асуудлыг тодруулах зорилготой асуулга судалгааг авч нэгтгэн дүгнэхийн зэрэгцээ оролцогч бүрт дижитал батламж олгосон. Оролцогчид тус семинарын зохион байгуулалт, үр өгөөжийг өндөрөөр үнэлсэн бөгөөд чанар, хүртээмж нь жилээс жилд улам сайжирч, жил бүр хүсэн хүлээдэг семинар боллоо хэмээн дурьдсан байна. Цаашид тус семинарын практик ач холбогдолыг нь улам нэмэгдүүлэх үүднээс бүх шатны гадаад хэлний багш нарын оролцоотой богино, дунд хугацааны төсөлт сургалтуудыг хамтран хэрэгжүүлж бодит үр дүнгийн талаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж байх нь семинарын үр өгөөжийг дээшлүүлэх сайн талтай гэж дүгнэлээ.

The image shows a Zoom webinar interface. On the left, there is a grid of 25 small video windows, each showing a different participant. On the right, there is a large blue banner with white and yellow text. The banner features the logo of the Mongolian State University of International Studies (MSUIS) in the top left corner. The main title of the banner is "ГАДААД ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ӨНӨӨГИЙН ЧИГ ХАНДЛАГА" (Foreign Language Education Trends). Below the title, it says "ОНЛАЙН ВЕБИНАР-2022" (Online Webinar-2022) and "4-р сарын 9 10:00 цагт" (April 9, 10:00 AM). The banner also lists several speakers with their names and titles: Н. Оюунцэцэг (N. Oyuncetseg), Н. Нансалмаа (N. Nansalmaa), С. Чимэдцогзол (S. Chimedtsojzol), Ж. Төгсөө (J. Togsyev), Н. Ариунаа (N. Ariunaa), and Ш. Нандинцэцэг (Sh. Nandintsetseg). At the bottom right of the banner, it says "МЭДЛЭГЭЭ ХУВААЛЦЬЯ, ХАМТДАА ХӨГЖЬЕ" (Share your knowledge, let's grow together) and "ХОЛБОО БАРИХ: 96012045, 95174292".

Үйл явдлууд

Мандах Их сургуулийн үүсгэн байгуулагдсаны 30 жилийн ой боллоо

2022 оны 05 сарын 29-ны өдөр Мандах Их сургууль үүсгэн байгуулагдсаны 30 жилийн ойгоо тэмдэглэн өнгөрүүлээ.

Ойн хүрээнд тус сургуулийн хамт олон, сургалт эрдэм шинжилгээ, нийгэм хүмүүнлэг, бүтээн байгуулалтын олон төрлийн ажлуудыг шинээр санаачлан зохион байгуулахын зэрэгцээ олон олон амжилтаар түүхт ойгоо угтлаа.

Шинээр болон ойд зориулан зохион байгуулсан ажлууд :

- Сургуулийн бүтэц, бүрэлдэхүүнийг өргөтгөн Ахисан түвшний сургууль, Нягтлан бодох бүртгэлийн сургууль, Инженер, эдийн засгийн сургуулиудыг байгуулав.
 - TV9 телевизийн “Мөрөөдөл биелэдэг юм” нэвтрүүлэгтэй хамтран Санхүүгийн бэрхшээлтэй 5 сурагчийг 4 жилийн 100%ийн сургалтын тэтгэлэгтэй суралцах эрх олгон суралцуулж байна.
 - Төгсөгчдийн форум-2022 болон Төгсөгчдийн нэрэмжит сагс, волейболын тэмцээнийг зохион байгуулав.
 - Олон Улсын Эрдэм Шинжилгээний хурал “МАНДАХ 2022”-ыг зохион байгуулав.
 - ЕБС-ийн сурагчдын дунд “МОНГОЛ ХҮНИЙ ҮНЭТ ЗҮЙЛГ” илтгэлийн улсын уралдаан, Логик сэтгэлгээийн мини олимпиадыг зохион байгуулав.
 - Сургуулийн түүхийн танхим, багш ажилтны хөгжлийн төв, сургуулийн түүхийн ном, баримтат киног хийж бүтээв.
 - Оюутны өөртөө үйлчлэх хэвлэх үйлчилгэг нэвтрүүлж, орчин үеийн тоног төхөөрмжөөр анги танхим болон цахим сургалтын өрөөг тохижуулав.
- “Зүрх мартахагүй”, “Ид шидийг орон” төслүүдийг дэмжих аян, MAGEC BOX” –д ном хандивлах аяныг өрнүүлж, багш оюутнууд идэвхтэй оролцлоо.

Амжилтууд:

- НББ-ийн улсын XXIII олимпиадад ТЭРГҮҮН байр
 - Статистикийн улсын IV олимпиадад ДЭД байр
 - Үндэсний программчлалын улсын олимпиадад ГУРАВДУГААР байр
 - Татварын бүртгэл 2021 олимпиадад багш нар 1,3, оюутнууд 4,5,8,9–р байрт
 - ТАТВАРЫН ХУУЛИЙГ ХЭН САЙН МЭДЭХ ВЭ?” тэмцээнд оюутнууд багаараа 2,4-р байрт
 - Эрдмийн шувуу ОЭШХ-д дэд байрт
 - Хаан банкны IX олимпиадад тус тус шалгарлаа.
- Инженер эдийн засгийн хөтөлбөрийн анхны диплом хамгаалалт анхны төгсөлтийг хийв.



Мандах их сургууль болон “Грант Торнтон Аудит” ХХК-ний хооронд хамтран ажиллах тухай гэрээ байгууллаа

Мандах их сургууль болон “Грант Торнтон Аудит” ХХК-ний хооронд хамтран ажиллах тухай гэрээ байгуулж, Мандах их сургуулийн захирал, Профессор Г.Нанжид, “Грант Торнтон Аудит” ХХК-ний ерөнхийлөгч Б.Осоргарав нар 2022 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр гарын үсэг зурлаа.

“Грант Торнтон Аудит” ХХК нь АНУ-д төвтэй Олон улсын Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний дэлхийн 130 гаруй орны 60000 ажилтнуудаас бүрдсэн сүлжээ байгууллагын гишүүн, бие даасан фирм юм.

Хоёр тал хамтын ажиллагааны гэрээнд тусгагдсан үйл ажиллагааны дагуу оюутнуудын дадлагын ажлыг үр дүнтэй зохион байгуулах, суралцагсдыг цагийн болон үндсэн ажлын байраар хангах, шилдэг оюутнуудад зориулсан тусгай төсөл хөтөлбөрийг зохион байгуулах, ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх сургалт семинар зохион байгуулах, хамтарсан судалгаа хийх чиглэлээр хамтран ажиллахаар санал солилцлоо.



**Мандах их сургууль, Индонези улсын Шинжлэх ухаан,
Компьютер технологийн Стеком их сургуультай Олон улсын
вэбинар хамтран зохион байгууллаа**

Мандах их сургууль, Индонези улсын Шинжлэх ухаан, Компьютер технологийн Стеком их сургуультай байгуулсан хамтын ажиллагааны санамж бичигт тусгагдсан ажлын хүрээнд Олон улсын вэбинарыг “Хүнсний үйлдвэрт нано-технологийг нэвтрүүлэх нь” сэдвийн дор 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдөр онлайн хэлбэрээр зохион байгууллаа. Вэбинарт Бангладеш, Индонези, Монгол улсаас 60 гаруй оролцогчид оролцсон ба Мандах их сургуулийн Инженер-технологийн тэнхимийн эрхлэгч, доктор багш Д.Түвшинжаргал “Инженерийн сургалтын арга зүйг сайжруулах зарим асуудлууд” сэдвээр илтгэл тавьж, амжилттай хэлэлцүүлээ.



Гадаад хамтын ажиллагаа

Индонези улсын Шинжлэх ухаан, Компьютер технологийн Стеком их сургууль, Индонезийн Ухаалаг Багш нарын Нийгэмлэгээс хамтран зохион байгуулсан “Зочин багшийн лекц” хөтөлбөрт Мандах их сургуулийн багш амжилттай оролцлоо

Индонези улсын Шинжлэх ухаан, Компьютер технологийн Стеком их сургууль, Индонезийн Ухаалаг Багш нарын Нийгэмлэг хамтран “Зочин багшийн лекц” хөтөлбөрийг 2022 оны 3-р сарын 28-наас 4-р сарын 1-ний өдрүүдэд онлайн хэлбэрээр зохион байгууллаа. Тус арга хэмжээнд Мандах их сургуулийн 4 багш Индонезийн Стеком их сургуулийн эдийн засаг, бизнесийн чиглэлээр суралцаж байгаа 130 гаруй оюутнуудад лекц уншлаа. Хөтөлбөрийн эхний өдөр Бүртгэл, шинжилгээний тэнхимийн багш Ц.Номин “Хувь хүнд чиглэсэн онлайн зар сурталчилгааны эерэг ба сөрөг тал” сэдвээр, 2 дахь өдөр Эдийн засаг, бизнесийн тэнхимийн багш Л. Дансранбавуу “Монголын Санхүүгийн зах зээлийн зарим асуудлууд” сэдвээр, 3 дахь өдөр Бүртгэл, шинжилгээний тэнхимийн багш Э. Ундрал “Хөрөнгө босголт” сэдвээр, хөтөлбөрийн сүүлчийн өдөр буюу 4-р сарын 1-нд Эдийн засаг, бизнесийн тэнхимийн багш А.Дөлгөөн “Экспортын зээлийн батлан даалтын агентлагийн ач холбогдол” сэдвээр тус тус лекц уншлаа.



The poster is for a "Visiting Lecture" event. At the top, it features logos for Mandakh University, Universitas Stekom, and Sekolah Tinggi Ilmu Ekonomi Stekom. The main title is "VISITING LECTURE" with flags of Indonesia and Mongolia. Below the title, it states: "Let's join the visiting lecture with Mandakh University (Mongolia) in Collaboration with University of Science and Computer Technology (STEKOM University)".

Lecturer	Department	Topic	Day	Date	Time
Nomin Tsembel	Lecturer of Department of Accounting and Analysis	"Personalized online advertising: Two-edged sword"	MONDAY	March 28, 2022	10.00 WIB
Dansranbavuu Lkhagvaa	Lecturer of Economics and Business Department	"Some issues of Mongolian Financial Market"	TUESDAY	March 29, 2022	10.00 WIB
Undral Erdenee	Lecturer of Department of Accounting and Analysis	"Raising Capital"	THURSDAY	March 31, 2022	10.00 WIB
Dulguun Altangerel	Lecturer of Economics and Business Department	"Export crediting agency's importance in development"	FRIDAY	April 1, 2022	10.00 WIB

At the bottom, there is a QR code and contact information: Zoom: bit.ly/meet-BusinessMarket, Daftar: bit.ly/daftar-BusinessMarket, YouTube: bit.ly/live-BusinessMarket1, Informasi: 08588 00000 11. A gold seal says "GRATIS: Ilmu bermanfaat, eSertifikat 11-5 terverifikasi, verifikasi.me". Logos for Universitasstekom, www.stekom.ac.id, mandakh.edu.mn, and TopLoker.com are at the very bottom.

Дотоод хамтын ажиллагаа

Мандах их сургууль болон “Грант Торнтон Аудит” ХХК-ний хооронд хамтран ажиллах тухай гэрээ байгууллаа

Мандах их сургууль болон “Грант Торнтон Аудит” ХХК-ний хооронд хамтран ажиллах тухай гэрээ байгуулж, Мандах их сургуулийн захирал, Профессор Г.Нанжид, “Грант Торнтон Аудит” ХХК-ний ерөнхийлөгч Б.Осоргарав нар 2022 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр гарын үсэг зурлаа.

“Грант Торнтон Аудит” ХХК нь АНУ-д төвтэй Олон улсын Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний дэлхийн 130 гаруй орны 60000 ажилтнуудаас бүрдсэн сүлжээ байгууллагын гишүүн, бие даасан фирм юм. Хоёр тал хамтын ажиллагааны гэрээнд тусгагдсан үйл ажиллагааны дагуу оюутнуудын дадлагын ажлыг үр дүнтэй зохион байгуулах, суралцагсдыг цагийн болон үндсэн ажлын байраар хангах, шилдэг оюутнуудад зориулсан тусгай төсөл хөтөлбөрийг зохион байгуулах, ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх сургалт семинар зохион байгуулах, хамтарсан судалгаа хийх чиглэлээр хамтран ажиллахаар санал солилцлоо.



Дотоод хамтын ажиллагаа

Мандах их сургууль болон “АПУ ХК” –ний хооронд хамтран ажиллах тухай гэрээ байгууллаа


Мандах их сургууль болон “АПУ ХК -ний хооронд хамтран ажиллах тухай гэрээ байгуулж, 2022 оны 5-р сарын 16-ны өдөр Мандах их сургуулийн Сургалт эрхэлсэн дэд захирал, Доктор (Ph.D), дэд Профессор Ч. Төрбадрах, “АПУ ХК”-ний Захиргаа, Хүний нөөц эрхэлсэн захирал Ж. Ичинхорлоо нар гарын үсэг зурлаа.

Гарын үсэг зурах ёслолын ажиллагааны үеэр хоёр тал хамтын ажиллагааны гэрээнд тусгагдсан үйл ажиллагааны дагуу оюутнуудын дадлагын ажлыг үр дүнтэй зохион байгуулах, суралцагсдыг цагийн болон үндсэн ажлын байраар хангах, шилдэг оюутнуудад зориулсан тусгай төсөл хөтөлбөрийг зохион байгуулах, ажилтнуудад боловсролын зэрэг олгох, зэрэг ахиулах сургалт дамжаа зохион байгуулах чиглэлээр хамтран ажиллахаар санал солилцлоо.



“MANDAKH-2022” Олон улсын эрдэм шинжилгээний хурал амжилттай зохион байгуулагдлаа

Мандах Их Сургууль нь 2012 оноос эхлэн эрдэмтэн судлаачдын дунд олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2-3 жил тутам тогтмол зохион байгуулдаг уламжлалтай билээ. Энэ удаагийн “MANDAKH-2022” олон улсын 5 дах удаагийн эрдэм шинжилгээний хурлыг Мандах Их Сургууль үүсгэн байгуулагдсны 30 жилийн ойг тохиолдуулан “ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ БА ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ” сэдвийн хүрээнд цахим болон танхим хосолсон хэлбэрээр 2022 оны 5-р сарын 27-ны өдөр Holiday Inn зочид буудлын 2 давхарт Ballroom танхимд амжилттай зохион байгууллаа. Энэхүү олон улсын эрдэм шинжилгээний хурлыг дэмжигч байгууллагаар Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи, Монголын Үндэсний Статистикийн хороо, оролцогч байгууллагаар Зайгал судалгааны институт, Мишээл судалгааны институт, МУИС, ШУТИС, ХААИС, СЭЗИС зэрэг сургуулиудын эрдэмтэн судлаачид оролцлоо. Мөн НҮБ-ийн Хүүхдийн сан, Австрали, Канад, АНУ, БНХАУ, Индонез, Мьянмар, Өмнөд Солонгос зэрэг улс орнуудын 20 гаруй эрдэмтэн судлаачид илтгэлээ хэлэлцүүлээ. Уг хурлыг зохион байгуулснаар гадаад дотоодын эрдэмтэн судлаачид харилцан туршлага солилцох, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх боломжийг олгож байдгаараа чухал ач холбогдолтой юм



“Тогтвортой, хүртээмжтэй хөгжил” оюутны эрдэм шинжилгээний хурал амжилттай зохион байгуулагдаж шилдгүүдийг тодрууллаа

Мандах Их сургуулийн 30 жилийн ойн хүрээнд ЭЗБТ-с “Тогтвортой, хүртээмжтэй хөгжил” сэдэвт оюутны эрдэм шинжилгээний хурал зохион байгууллаа. Энэхүү хурал нь үндсэн 2 үе шаттай зохион байгуулагдаж, 2-р шатанд Мандах ИС, СЭЗИС, ХААИС, ХУИС, ШУТИС, McGill гэсэн нийт 6 сургуулийн 12 илтгэл шалгарч 2022.04.22-ны өдөр танхим, болон цахим хослуулан илтгэлийг хэлэлцүүлэн шилдгүүдийг тодрууллаа. андах ИС-ийн ахисан түвшний захирал, доктор профессор С.Цолмон хурлын үйл ажиллагааг албан ёсоор нээж, нийт оролцогч нарт амжилт хүслээ. Хурлын үйл ажиллагааг дэмжиж жил бүр гаднын нэр хүндтэй, тэргүүлэх их сургуулиудын доктор багш нар, мэргэжлийн байгууллагын судлаач, мэргэжилтнийг урьж оролцуулдаг онцлогтой. Энэ удаагийн хурлын үйл ажиллагааг дэмжиж дараах багш нар шүүгчээр оролцлоо.

ШУТИС, БАТС-ийн сургалт эрхэлсэн дэд захирал, Доктор /Ph.D/, дэд профессор М.Банзрагч

ХУИС-ийн Бизнесийн сургуулийн багш Доктор /Ph.D/, дэд профессор А.Амаржаргал

СЭЗИС -ийн багш Доктор /Ph.D/, ОУ-ын мэргэшсэн нягтлан бодогч /ACCA/ Л.Ундаргаа

Мандах ИС-ийн ЭЗБТ-ийн багш Л.Дансранбавуу багш нар шүүгчээр ажиллалаа.

Энэ удаагийн хурлын нэг онцлог нь танхим болон цахим хослон зохион байгуулагдсан нь дотоодын төдийгүй гадаад сурч буй оюутнууд өөрсдийн эрдэм шинжилгээний ажлын бүтээлээрээ оролцох боломжтой явдал байсан юм. Мөн шүүлтгийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдэд томоохон өөрчлөлт оруулсан бөгөөд зохиогчийн эрхийн зөрчилгүй, бусад судлаачийн санааг шууд болон дам давтахгүй байх чиглэлд анхаарч илтгэл тус бүрийн хуулбарлалтыг шалган үнэлгээнд тусгасан явдал юм. Түүнчлэн шүүгч багш нар өөрсдийн сургуулийн оюутнуудын илтгэл дээр оноо тавихгүй байхаар зохион байгуулалтыг хийсэн нь хурлын шүүлтгийн үйл ажиллагааны бас нэг онцлог байв.

Шүүгчдийн нэгдсэн үнэлгээгээр дараах илтгэлүүд шилдэг илтгэлээр шалгарч, өргөмжлөл мөнгөн шагналын эзэн боллоо.

ХУИС-ийн Менежментийн ангийн 4-р дамжааны оюутан Г.Баясгалан 94 оноогоор “Бизнесийн байгууллага цар тахлын дараах үед маркетингийн стратегийг оновчтой хэрэгжүүлэх арга зам” сэдэвт илтгэлээр тэргүүн байр, өргөмжлөл, мөнгөн шагнал

Мандах ИС-ийн Санхүү менежмент ангийн 4-р дамжааны оюутан Х.Гүлнур 88.67 оноогоор “Ковид-19 цар тахлын эсрэг төрөөс хэрэгжүүлж буй бодлогын эдийн засагт үзүүлж буй үр нөлөө (Уул уурхайн экспорт давамгайлсан улс орнуудын жишээн дээр)” сэдэвт илтгэлээр дэд байр, өргөмжлөл, мөнгөн шагнал

Мандах ИС-ийн НББ-Аудит ангийн 4-р дамжааны оюутан Э.Эрдэнэбилэг 86.33 оноогоор “Ковид-19 цар тахлын эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөлөл сэдэвт илтгэлээр ” сэдэвт илтгэлээр гутгаар байр, өргөмжлөл, мөнгөн шагнал

ШУТИС-ийн Олон улсын бизнесийн менежментийн ангийн 3-р дамжааны оюутан Г.Есүй 86 оноогоор “Cultural Influence in the Organization, the Effect of Power Distance and Masculinity on Productivity in Civil Servants Through Skill” сэдэвт илтгэлээр тусгай байр, өргөмжлөл, мөнгөн шагнал

Хурлын төгсгөлд Мандах ИС-ийн ЭЗБТ-ийн эрхлэгч С.Мөнхцэцэг болон шүүгч нарын төлөөллүүд нийт илтгэгч нарт хандаж судалгааны ажлын ололт амжилт, цаашид анхаарч сайжруулах чиглэлд үнэт зөвлөгөөг өгөхийн зэрэгцээ жил ирэх тусам илтгэлийн чанар, чансаа, ач холбогдол өндөр болж байгааг онцолж сайшаалаа.



Нягтлан бодох бүртгэлийн улсын XXIII олимпиадад мандах их сургууль тэргүүлээ

ММНБИ-ийн үүсгэн санаачлагчдын нэг, хүндэт багш, Мандах Их Сургуулийн гүйцэтгэх захирал, доктор, профессор С.Өлзийбат агсны нэрэмжит “Нягтлан бодох бүртгэлийн улсын XXIII олимпиад” 2022 оны 4-р сарын 14,15-ны өдрүүдэд Мандах Их Сургууль дээр зохион байгуулагдлаа. 4-р сарын 14-ний өдөр олимпиадын 1-р шатанд МУИС, СЭЗИС, ХААИС, Мандах ИС, Мандах ИС-ийн Дархан уул аймаг дахь салбар сургууль, Төрийн өмчит Улаанбаатарын ИС, Улаанбаатар Эрдэм ИС, Идэр ИС, Этүгэн ИС, ОУЭЗБИС гэсэн 10 сургуулийн 50 оюутан өрсөлдөж 2022 оны ТОП-10 оюутныг шалгаруулсан.

2022 оны ТОП-10 оюутан

1. Баярмагнай овогтой Дэлгэрмагнай, Мандах ИС, 118 оноо
2. Баттөр овогтой Бадрах, СЭЗИС, 98 оноо
3. Батхуяг овогтой Билэгмаа, СЭЗИС, 88 оноо
4. Хүдэрбат овогтой Намуундарь, Мандах ИС-ийн Дархан уул аймаг дахь салбар сургууль, 87 оноо
5. Энхтүвшин овогтой Энхдэлхий, Мандах ИС-ийн Дархан уул аймаг дахь салбар сургууль, 82,5 оноо
6. Алтангэрэл овогтой Түмэнжаргал, СЭЗИС, 81,5 оноо
7. Өлзийбаяр овогтой Отгонзул, СЭЗИС, 77,5 оноо
8. Нямбаяр овогтой Уянга, Мандах ИС, 76 оноо
9. Зоригтбаатар овогтой Намуун-Эрдэнэ, Мандах ИС, 72 оноо
10. Батбаатар овогтой Дорждэрэм, Мандах ИС, 71,5 оноо

2022 оны 4 сарын 15-ны өдөр олимпиадын 2-р шатны шалгаруулалт болж оюутнууд багаар кейс дасгалууд дээр ажиллаж, хувийн дүнгээр авсан оноо болон багаар ажилласан кейс, дасгалын онооны нийлбэрээр багийн дүнг гаргаж Мандах Их Сургуулийн баг тэргүүлж алтан медаль хүртлээ.

2022 оны багийн амжилт

Мандах их сургууль 564.5 оноогоор 1-р байр, Алтан медаль

СЭЗИС 528.5 оноогоор 2-р байр, Мөнгөн медаль

Мандах ИС-ийн Дархан уул аймаг дахь салбар сургууль 433 оноогоор 3-р байр, Хүрэл медаль



Статистикийн улсын IV олимпиад амжилттай зохион байгуулагдлаа

Мандах Их Сургуулийг үүсгэн байгуулагч Б.Сандагсүрэн агсны нэрэмжит Статистикийн улсын IV олимпиад 2022 оны 04 сарын 23-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Уламжлал ёсоор Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ) тус олимпиадын дэмжигч байгууллагаар ажиллав.

Олимпиадын шагнал гардуулах ёслолын үйл ажиллагаанд:

Монгол улсын гавьяат багш, доктор профессор Г.Элдэв-Очир,

Монгол Улсын гавьяат багш, доктор, профессор, шатрын спортын олон улсын хэмжээний мастер С.Хандсүрэн

ҮСХ-ны дарга Б.Батдаваа,

ҮСХ-ны Бодлого хамтын ажиллагааны газрын Хамтын ажиллагаа, тархаалтын хэлтсийн дарга Л.Цэвээнжав,

ҮСХ-ны Бодлого хамтын ажиллагааны газрын Хамтын ажиллагаа тархаалтын хэлтэсийн зохион байгуулагч Б.Бат-Итгэл,

Мандах ИС-ийн удирдлагууд хүндэт зочдоор оролцлоо.

Мандах ИС-ийн захирал профессор Г.Нанжид олимпиадын шагнал гардуулах ёслолын үйл ажиллагааг нээж хэлсэн үгэндээ “Энэ удаагийн олимпиад Мандах Их Сургуулийн 30 жилийн ойн босгон дээр зохион байгуулагдаж буй”-г онцлон тэмдэглэлээ. Үүсгэн байгуулагч Бүдхүүгийн Сандагсүрэнгийн ажил амьдрал, бүтээл туурвилын талаар хүү С.Энхтүвшин дурсамж танилцуулга хийв.

Мөн МУ-ын ҮСХ-ний дарга Б.Батдаваа статистикч мэргэжлийн онцлог давуу тал цаашид статистикийн шинжлэх ухааны ач холбогдол улам өсөх талаар дурьдаж, Мандах ИС-тай хамтын ажиллагааны хүрээнд эрдэм шинжилгээ судалгаа хийх, мэдээлэл солилцох, оюутныг дадлагажуулах чиглэлээр хамтран ажиллаж ирсэнд таатай байгаагаа илэрхийллээ.

Энэхүү олимпиадад МУИС-ийн Бизнесийн сургууль, Мандах Их Сургууль, СЭЗИС, Их засаг ОУИС, Роял академи зэрэг их сургуулиудын I, II курсийн 50 гаруй оюутан залуус статистикийн мэдлэг чадвар, авхаалж самбаагаа сорин оролцсоноос багийн дүнгээр СЭЗИС 1-р байр, Мандах Их Сургууль 2-р байр, Их Засаг ОУИС 3-р байр эзэллээ.

Хувийн дүнгээр Мандах ИС-ийн оюутан Ц.Оюун-Эрдэнэ, Х.Цолмон-Эрдэнэ, О.Азжаргал, СЭЗИС-ийн оюутан З.Тэмүүжин, Б.Даваадэмбэрэл, А.Төгөлдөр, Н.Билгүүн, Э.Чинзориг, О.Батзаяа, Их засаг ОУИС-ийн оюутан А.Мөнх-Уянга, Б.Сэр-Од нар эхний 10 байрт шалгарч Өргөмжлөл, мөнгөн шагнал болон ҮСХорооны дурсгалын зүйлийг гардан авлаа.



Шутис-ын оюутны эрдмийн XXI чуулганы эдийн засаг, менежментийн салбар хуралдаанд дэд байр эзэлсэн амжилтыг Үзүүллээ

Монгол Улсын их сургуулиудын хүрээнд уламжлал болгон зохиогддог “Эрдмийн XXI чуулган” шилдэг өгүүлэл шалгаруулах оюутны эрдэм шинжилгээний хурал 2 үе шаттай, 4 салбар хуралдаанаар 2022.04.09-ны өдөр 21 дэх жилдээ амжилттай зохион байгуулагдаж шилдэг илтгэлүүдийг шалгарууллаа. Тус хуралд ШУТИС-ийн бүрэлдэхүүн 9 сургууль, орон нутгийн 2 сургуулиас гадна бусад 5 их сургуулийн 90 гаруй оюутан нийт 43 илтгэлээр оролцсон байна.

Эдийн засаг, менежментийн салбар хуралдаан нь “Эрдмийн шувуу” нэртэйгээр XIX жилдээ зохион байгуулагдаж байгаа бөгөөд тус салбар хуралдаанд Мандах ИС-ийн докторант багш Ж.Гантулгын удирдлаган дор НББ-Аудит хөтөлбөрийн 4-р дамжааны оюутан Э.Эрдэнэбилэг “Ковид-19 цар тахлын эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөлөл” сэдэвт илтгэлээр дэд байрт шалгарч өргөмжлөл 500,0 мянган төгрөгөөр шагнууллаа.



Шагнал урамшуулал

Төрийн дээд “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор шагнууллаа

Мандах Их Сургуулийн ахмад багш, Хүндэт профессор, Доктор /Ph.D/ Ц.Ядамсүрэн сар шинийн босгон дээр Монгол улсын ерөнхийлөгчийн зарлигаар “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон ”-оор шагнууллаа. Ц.Ядамсүрэн нь боловсрол, шинжлэх ухааны салбарт олон жил үр бүтээлтэй ажилласныг ийнхүү төрөөс үнэлжээ.



Ц.Ядамсүрэн багшдаа цаашдын ажил хөдөлмөрт нь өндөр амжилт, амьдралд нь эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг сургуулийн нийт хамт олны өмнөөс хүсэн ерөөе.

Тэмцээн уралдаан

“Мандах их сургуулийн оюутнууд “САНХҮҮГИЙН УЛСЫН VIII ОЛИМПИАД”-д амжилттай оролцлоо

“САНХҮҮГИЙН УЛСЫН VIII ОЛИМПИАД” нь 2022.03.18 – 03.25-ны өдрүүдэд 2 үе шаттайгаар зохион байгуулагдсан ба эхний шатанд 8 их, дээд сургуулийн 13 багийн 65 оюутан оролцож, II шатанд 6 баг шалгаран өрсөлдөв. Мандах их сургуулиас Blades болон Squadron гэсэн 2 баг тус олимпиадад оролцсон бөгөөд багийн дүнгээр II шатанд Blades баг шалгарч амжилттай оролцож V байр, багш нарын баг III-р байранд шалгарав. Санхүүгийн болон хөрөнгө оруулалтын ахисан түвшний менежерүүдэд тавигддаг гол шалгууруудын нэг бол “CFA” буюу “Олон улсын мэргэшсэн санхүүгийн шинжээч”-ийн зэрэг байдаг. Тус олимпиадын эхний шат CFA бэлтгэх номны агуулгаар явагддаг ба дараагийн шат санхүү менежмент, санхүү шинжилгээ, хөрөнгө оруулалтын агуулгын хүрээнд компаниудын кейс дээр тулгуурлан шинжилгээ хийн өрсөлддөгөөрөө онцлог юм.

“BLADES” БАГ” Мандах Их Сургуулийг төлөөлөн оролцсон Санхүү менежментийн хөтөлбөрийн 3-р дамжааны оюутан Г.Хүслэн, Г.Анхбаяр, Банкны менежментийн хөтөлбөрийн 4-р дамжааны оюутан Д.Сайнзаяа, Ц.Нансалмаа, Ө.Номин-Эрдэнэ болон багаа удирдан оролцсон Г.Лхамдулам, А.Дөлгөөн багш нартаа баяр хүргэж цаашдын эрдмийн ажилд нь өндөр амжилт хүсье.



Тэмцээн уралдаан

Мандах Их Сургуулийн үүсгэн байгуулагч Б.Сандагсүрэнгийн нэрэмжит 4 төрөлт спорт тэмцээн амжилттай боллоо.

Мандах Их Сургуулийн 30 жилийн ойг тохиолдуулан Инженер Эдийн Засгийн Сургуулийн СШУТ-ээс зохион байгуулсан “МОНГОЛ ХҮНИЙ ҮНЭТ ЗҮЙЛ” илтгэлийн улсын уралдааны дүн гарлаа.

Тус илтгэлийн уралдааныг 2022 оны 02 сарын 28-наас 04 сарын 05-ны хүртэл 2 үе шаттай зохион байгууллаа.

Илтгэлийн уралдааны нэгдүгээр шатыг 2022 оны 02 сарын 28-наас 03 сарын 28-ны хооронд явуулахад Говьсүмбэр, Дархан-Уул, Завхан, Ховд, Дорнод зэрэг 5 аймгийн, мөн Г.В.Плехановын нэрэмжит Оросын Эдийн Засгийн Их Сургуулийн Улаанбаатар дахь салбар сургууль, “Мандах лицей” ахлах сургууль, “Шинэ-Өнөөдөр” сургууль, 44-р сургууль, 106-р сургуулийн сурагчдын 57 илтгэл ирүүлсэн байна.

Хоёрдугаар шатны шалгаруулалт 2022 оны 04 сарын 06-ны өдөр цахим болон танхим хосолсон хэлбэрээр болж шилдэг 10 илтгэлийг хэлэлцүүлэхэд:

Тэргүүн байрт: Дархан-Уул аймгийн 15 сургуулийн 11а ангийн сурагч М.Эгшиглэн

Дэд байрт: Хан-Уул дүүргийн “Шинэ-Өнөөдөр” сургуулийн 11а ангийн сурагч Н.Мандухай, Г.Шинэ-Оргил

Гутгаар байрт: Завхан аймгийн Улиастай сумын Жавхлант цогцолбор сургуулийн 12б ангийн сурагч М.Оюунсондор, Т.Нямгэрэл

Тусгай байрт: Баянгол дүүргийн “Мандах лицей” ахлах сургуулийн 11а ангийн Ө.Хандсүрэн нарын илтгэл тус тус шалгарлаа.



Авъяаслаг Мандахчууд

1-р курсын оюутнуудын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Оюутны урлагийн наадам” 2022 оны 03 сарын 28-ны өдрөөс 4 сарын 2-ны өдөр хүртэл 7 хоног амжилттай болж өндөрлөлөө. Энэ хичээлийн жилийн оюутны урлагийн наадмын онцлог нь ковид цар тахлын улмаас нэг жил завсарласан “Оюутны урлагийн наадам” 1, 2-р курс тус бүрээр шалгарууллаа. Түүнээс гадна дуу, бүжиг, язгуур урлаг гэсэн 3 төрөлд шилдэгүүдийг тодруулж, Нэгдсэн дүнгээр Авъяаслаг ангийг шалгарууллаа.

2-р курсын шилдэгээр: Дууны төрөлд: Нягтлан бодох бүртгэл, мэдээллийн систем хөтөлбөрийн 2-р курсын үзүүлбэр

Бүжгийн төрөлд: Санхүү менежмент хөтөлбөрийн 2-р курсын үзүүлбэр

Язгуур урлагийн төрөлд: Банкны менежмент хөтөлбөрийн 2-р курсын үзүүлбэр тус тус шалгарлаа.

Нэгдсэн дүнгээр:

65,3 оноогоор Нягтлан бодох бүртгэл татвар-2

62,5 оноогоор Санхүүгийн менежмент- 2

61 оноогоор Нягтлан бодох бүртгэл, аудит-2 ангийн хамт олон тус шалгарлаа.

1-р курсын шилдэгээр:

Дууны төрөлд: Нягтлан бодох бүртгэл, мэдээллийн систем хөтөлбөрийн 1-р курсын үзүүлбэр

Бүжгийн төрөлд: Санхүү менежмент хөтөлбөрийн 1-р курсын үзүүлбэр

Язгуур урлагийн төрөлд: Нягтлан бодох бүртгэл, англи хэл хөтөлбөрийн 1-р курсын үзүүлбэр тус тус шалгарлаа.

Нэгдсэн дүнгээр:

72 оноогоор Нягтлан бодох бүртгэл, мэдээллийн систем -1

66,8 оноогоор Нягтлан бодох бүртгэл, татвар -1

63,5 оноогоор Маркетингийн менежмент -1 ангийн хамт олон тус тус шалгарлаа.



Редакцийн зөвлөл:

Ч.Төрбадрах / Сургалтын эрхэлсэн дэд захирал /
И-мэйл: turbadrakh@mandakh.edu.mn

З.Булганаа / Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан ажилтан /
И-мэйл: foreignrelations@mandakh.edu.mn

Г.Энхжин/ Сургалтын алба/
И-мэйл: Enkhjin@mandakh.edu.mn